



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Багшийн хөгжлийн ордон, Энхтайваны өргөн чөлөө 10а,  
11 дүгээр хороолол, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191  
Утас/Факс: (976) 7011-3033  
<http://www.edub.edu.mn>

2019. 05. 23 № 04/816

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА НАРТ

2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01/1581 дүгээр албан бичгээр хүргүүлсэн “Сургууль, цэцэрлэгийн эрүүл ахуйг сайжруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” тухай зөвлөмжийг дахин хүргүүлж байна.

Тус зөвлөмжийг нэгж байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийн тайлан мэдээг улирал бүрийн эхний сарын 10-ны дотор Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт 3 хуудас

ОРЛОГЧ ДАРГА  Л.ДАШДЭМБЭРЭЛ



1110800870

## **СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ДОТУУР БАЙРНЫ ЭРҮҮЛ АХУЙГ САЙЖРУУЛАХ, ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ**

Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нь “Байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх”<sup>1</sup>, “Хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийг эрүүлжүүлэх ... эрх бүхий байгууллагаас баталсан эрүүл ахуйн стандарт, хэм хэмжээ, журмыг чанд сахин биелүүлэх”<sup>2</sup>, “Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, ... халдварт болон халдварт бус өвчин, ... осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх”<sup>3</sup> –дээ Нийслэлийн Боловсролын газраас гаргасан дараах зөвлөмжийг чиглэл болгоно.

### **Нэг. Цэвэрлэгээ, ариутгал хийх чиглэлээр**

- 1.1 Цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийж гүйцэтгэх ажлын хуваарь, төлөвлөгөөг баталгаажуулж гүйцэтгэл, үр дүнг тогтмол хянах
- 1.2 Их цэвэрлэгээг 10-14 хоног тутам, байнгын цэвэрлэгээг өдөр бүр тогтмол хийх
- 1.3 Шавж, мэрэгчийн устгал, ариутгал халдваргүйтгэлийг улирал бүр мэргэжлийн байгууллагаар хийлгэх
- 1.4 Байгууллагын орчинд хог цаас шатаахыг хориглох, хуурай хог цуглуулах таглаатай сав түүний орчин, бохирын цооног, бие засах газрын ариутгал цэвэрлэгээг тогтмолжуулах
- 1.5 Анги танхим, бүлгийн өрөө, коридор, гал тогоо, бие засах өрөөний цэвэрлэгээний алчуур, шалны мод, хувин зэрэгт тус бүр таних тэмдэг тавьж зориулалтаар нь хэрэглэн, халдваргүйтгэх
- 1.6 Хивс, хивсэнцэр, хөнжил, гудсыг тогтмол цэвэрлэх ба сар бүр нар салхинд 1-2 цаг тавьж хэвших
- 1.7 Хүүхдийн тоглоомыг өдөр бүр угааж цэвэрлэн халдваргүйжүүлэх
- 1.8 Шаардлагатай ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх
- 1.9 Бие засах газрын суултуур, гар угаагуурыг цэцэрлэг, яслид өдөрт 3 удаа, ерөнхий боловсролын сургуульд завсарлагаа бүрийн дараа цэвэрлэн халдваргүйжүүлж хэвших

### **Хоёр. Эрүүл мэндийн үзлэг, хяналтыг сайжруулах чиглэлээр**

- 2.1 Цэцэрлэгийн багш, туслах багш, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны багш, тогооч нарыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/145 дугаар тушаалаар батлагдсан журамд заасны дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах
- 2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг харьяа дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах
- 2.3 Урьдчилан сэргийлэх тарилгад /вакцин/ хамрагдвал зохих насны хүүхдийн судалгааг гарган, тарилгад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 2.3

<sup>2</sup> Эрүүл мэндийн тухай хууль 44.1.3

<sup>3</sup> Эрүүл ахуйн тухай хууль 13.1.4, 13.1.7

- 2.4 Хүүхдийн сургалт хүмүүжлийн ажлын ачаалал, өдрийн дэглэм, хоол хүнс, эрүүл мэнд, хувийн ариун цэвэр, хувцаслалтын байдалд хууль тогтоомжийн дагуу байнгын хяналт тавьж дутагдлыг арилгах чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах
- 2.5 Өглөө бүр хүүхдийн биеийн байдлыг хянан шаардлагатай тохиолдолд халууныг үзэж өвчний сэжиг илэрвэл эцэг эхэд мэдэгдэн харьяа дүүргийн эрүүл мэндийн байгууллагад хандах
- 2.6 Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сурагч, хүүхэд, багш, ажилчдад зориулан төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах, зөвлөмж, сэрэмжлүүлэг, мэдээлэл боловсруулан түгээх

#### **Гурав. Хүүхдийн хувийн ариун цэвэр, халдвар хамгааллын дэглэмийг сахих чиглэлээр**

- 3.1 Анги, танхим, бүлгийн өрөөнүүдийг өглөө, өдөр, оройн цагаар хүүхэдгүй үед 15-25 минут нэвт салхилуулах ба зуны улиралд 20-30 минут, хүйтний улиралд 10-20 минут зөвхөн салхивчийг нээж 2 цаг тутамд цэвэр агаар оруулж байх
- 3.2 Хүүхэд бүрт гарын алчуур, сам, шүдний оо, сойз, саван зэргийг тус тусад нь хэрэглүүлэн, тогтмол угааж халдваргүйжүүлж байх
- 3.3 Цэцэрлэг болон дотуур байранд хүүхдийг шаахай өмсүүлж хэвшүүлэх
- 3.4 Сурагчдыг ундны цэвэр ус уух хувийн аяга хэрэглүүлж хэвшүүлэх
- 3.5 Үдийн цай уусны дараа сурагчдын шүд угаах боломжийг бүрдүүлэх талаар судлан цаашид хэвшил болгох ажлыг зохион байгуулах
- 3.6 Хүүхдэд бохир гар, хуруу, үзэг харандаа, тоглоом зэргийг амандаа хийх, эзэнгүй нохой мууртай тоглох, нус цэрээ хаях, ил задгай бие засахгүй байх чиглэлээр зөвлөмж мэдээлэл хүргэн зохих дадлыг хэвшүүлэх
- 3.7 Цэцэрлэгийн хүүхэд бүрт өөрийн гудас, хөнжил, цагаан хэрэглэлийг хэрэглүүлэх ба ор хоорондын зайг 1 м-ээс багагүй байлгахад анхаарах
- 3.8 Анги танхим цэвэрлэх, хичээл хийх, тоглох, хооллох, бие зассаны дараа хүүхдийн гарыг тогтмол угаалгаж хэвших

#### **Дөрөв. Хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр**

- 4.1 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд “Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал” нэвтрүүлэх
- 4.2 Хоолны цэсийг БСШУЯ-наас гаргасан /Цэцэрлэгийн хоолны цэс, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ/ гарын авлагын дагуу байхаар төлөвлөх
- 4.3 Сургууль, цэцэрлэгийн цайны газарт харьяа дүүргийн мэргэжлийн хяналтын байгууллагаас дүгнэлт гаргуулах
- 4.4 Хоол хүнсэнд хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний дагалдах шинжилгээний бичгийг бүрдүүлэн ажиллах
- 4.5 Бүтээгдэхүүний дээжийг журмын дагуу авч зориулалтын хөргөгчинд 4<sup>0</sup>С температурт 72 цаг хадгалах, хоолны дээж авалтын бүртгэлийг хөтөлж, дээжний савыг ариутгаж хэвших
- 4.6 Онцгой хоолны дэглэмтэй /өвчлөл, хүнсний харшил, цагаан хоолтон/ сурагчдын хооллолтын судалгааг гарган түүний мөрөөр тодорхой ажил зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах
- 4.7 Улирлын онцлогт тохируулан цэсийг төлөвлөх. Хүйтний улиралд халуун ундааны зүйлээр /аарц, аньс, чацаргана г.м/ үйлчлэх

- 4.8 Боловсруулаагүй түүхий сүү, ус уух, угааж цэвэрлээгүй жимс, ногоо идэх, хүнсний зүйл болон аяга, халбага сэрээг ам дамжуулан хэрэглэхгүй байхад хяналт тавьж ажиллах
- 4.9 Ундны усны шинжилгээг стандартын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэн сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд эрүүл, аюулгүй ундны ус уух боломжийг бүрдүүлэн ажиллах

**Тав. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр**

- 5.1 Сургууль, цэцэрлэгийн удирдлага нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах
- 5.2 Багш, ажилчид, суралцагчдын дархлааг сайжруулах, чийрэгжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран үе шаттай зохион байгуулж үр дүнг тооцох
- 5.3 Сургууль, цэцэрлэгийн эмч нар хичээл сургалтын хугацаанд ирцийн тандалтыг өдөр бүр идэвхтэй хийж мэдээллийг харьяа дүүргийн боловсролын хэлтэст 7 хоног бүр хүргүүлэх
- 5.4 Цэцэглэг, сургуульдаа ирээгүй хүүхдийн шалтгааныг өдөрт нь шуурхай тогтоох, ямар нэгэн халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах
- 5.5 Халдварт өвчин тэр дундаа томуу, томуу төст өвчин, хоолны хордлого, гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах
- 5.6 Дархлаа сайжруулах цэгэн иллэгийг хүүхэд бүрт хийж хэвшүүлэх сургалтын арга хэмжээг зохион байгуулах
- 5.7 Дотоод агаарын чанарыг сайжруулах зорилгоор хичээл сургалтын хугацаанд агаар цэвэршүүлэгч төхөөрөмжийг тогтмол ажиллуулах
- 5.8 Халдварт өвчний тохиолдол илэрвэл харьяа өрх, дүүргийн эрүүл мэндийн төв, боловсролын хэлтэс, газарт шуурхай мэдээлэх
- 5.9 Халдварт өвчин гарсан үед анги, бүлэгт шинээр хүүхэд авах, анги, бүлгүүдийн хооронд шилжилт хөдөлгөөн хийхгүй байх

**НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**